

Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2016 оны 8 дугаар сарын байдлаар)

I. Нийгмийн үзүүлэлт




I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.

2016 оны 8 дугаар сард Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 895 болж, 2015 оны мөн үеэс 341 хүнээр буурч, өмнөх сарынхаас 144 хүнээр өсөв.

Ажилгүйчүүдийн 45.47 хувь буюу 407 нь эмэгтэйчүүд байна. 2016 оны эхнээс 451 ажлын байр захиалгад бүртгэгдсэн бол зуучлалаар 363 ажлын байранд иргэд ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 35.81 хувь буюу 130 нь эмэгтэйчүүд байв.

Зураг I.1


Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 8 дугаар сарын эцсийн байдлаар, өссөн дүнгээр



Тайлант сард бүртгүүлсэн 378 ажилгүй иргэний 27.78 хувь нь сургуулиа төгссөн, чөлөө авсан; 16.40 хувь нь цалин орлого хүрэлцэхгүй байгаа; 9.79 хувь нь шилжин суурьшсан; 7.41 хувь нь мэргэжил ур чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх; 7.14 хувь нь одоо эрхэлж байгаа ажлаа солих хүсэлтэй; 6.61 хувь нь орон тооны цомхтголоор; 4.23 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж орлогогүй болсон; 3.70 хувь нь гүйцэтгэж буй ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон; 3.17

хувь нь цэргээс халагдсан; 2.38 хувь нь байгууллага татан буугдсан; 1.32 хувь нь гадаадаас эргэж ирсэн; 0.53 хувь нь тэтгэвэрт гарсан; 0.53 хувь нь хорих газраас суллагдсан; 8.99 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ. Зураг I.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2016 оны 8 дугаар сарын эцэст



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



I.2 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2016 оны эхний 8 сард НДШ-ийн орлого 11.3 тэрбум ₮ болж төлөвлөгөө 98.88 хувь болж, төлөвлөгөөг 11 сум 2.52-29.23 хувиар давуулан биелүүлж. Архуст, Аргалант, Алтанбулаг, Баян, Баянхангай, Бүрэн, Батсүмбэр, Баянцагаан, Баянчандмань, Борнуур, Заамар, Мөнгөнморьт, Сэргэлэн, Эрдэнэ, Цээл, Зуунмод сумд 0.15-21.08 хувиар тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого 806.4 сая ₮ болж төлөвлөгөө 100.0 хувь биелүүллээ.

Тэтгэвэр, тэтгэмжинд 26.6 тэрбум ₮

зарцуулж, олголт 100.0 хувь боллоо. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 80.9 хувийг өндөр настны, 10.2 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.8 хувийг тэжээгчээ алдсаны, 5.1 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ. Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 269960 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 38.52 хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 28.47%; тэтгэмжийн даатгалын сангийн 66.28%; эрүүл мэндийн даатгалын сангийн 93.18%; үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 69.13%; ажилгүйдлийн даатгалын сангийн 83.53%-ийг тус бүр бүрдүүлжээ.

Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 8 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 52756 хүнд олгож, 8.7 тэрбум ₮-ийг зарцуулж 2015 оны мөн үеэс хүний тоо 4.7 хувь 2392 хүнээр, зарцуулсан мөнгөний хэмжээ 24.5 хувь 1.7 тэрбум ₮-өөр тус бүр өслөө.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 111740 ₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 44.86 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 21.51 хувийг халамжийн тэтгэвэр; 7.68 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 4.39 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 4.09 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж; 4.10 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж 0.68 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид тус бүр зарцуулжээ.




I.3 Эрүүл мэнд

2016 оны эхний 8 сард 11354 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 7.45 ор хоног ногдлоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2016 оны эхний 8 сард 846 хүүхэд мэндэллээ.

Зураг I.3


Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар



Аймгийн хэмжээнд он гарсаар 1 хүртэлх насандаа нас барсан хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 13 хүүхдээр өслөө.

Зураг I.4


Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар



2016 оны эхний 8 сард халдварт өвчнөөр 950 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 2,26 хувь буюу 21 хүнээр өслөө. 2015 оны мөн үеэс заг хүйтэн 90 хувь, тэмбүү 63,16 хувь, трихомениаз 48,57 хувь, вируст гепатит 25 хувь, улаан бурхан 11,06 хувь тус бүр өсчээ. 10000 хүнд ногдох халдварт өвчлөл аймгийн дундаж 104 байгаа бол: Зуунмод 279, Баян-Өнжүүлд 176, Баян 154, Архуст 142, Угтаал 109, Цээл 104 ногдлоо

Зураг I.5

10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн 7 дугаар сарын байдлаар



1.4 Байгаль орчин

- агаарын дундаж температур 15-20 градус дулаан буюу Өндөрширээт орчмоор дулаан Мөнгөнморьтоор сэрүүвтэр

- өдөр ажиглагдсан агаарын хамгийн дулаан температур нь 35-41 градус буюу Өндөрширээт, Лүн орчмоор 40-41 градус хүрч халсан байхад :Дэлгэрхаан, нутгийн зүүн хойд хэсэг болох Мөнгөнморьт, Эрдэнэ, Зууимод орчмоор 35 градус дулаан байв.

-шөнийн хугацаанд ажиглагдсан хамгийн бага температур 2,0 градус хүйтнээс 4,0 градус дулаан буюу Заамар орчмоор 4 градус дулаан, нутгийн зүүн хойд хэсгээр сэрүүвтэр Мөнгөнморьт орчмоор 2 градус хүйтэн байв.

-бүх нутгаар сарын нийлбэр хур тунадас 12,8-81,7 мм, нутгийн зүүн өмнөд хэсгээр бага үүнээс Баянжаргаланд 12,8 мм хамгийн бага нь, нутгийн баруун өмнөд, төв, зүүн хойд хэсэг болон зарим газраар арай ахиу, үүнээс хамгийн их нь Нөхөрлөлд 81,7 мм бороо оржээ.

-салхины их хурд нийт нутгаар 6-14 м/с, борооны өмнө түр зуур 16-20 м/с, Эрдэнэсантад 27 м/с хүрч ширүүслээ.

Олон жилийн дундажтай харьцуулсан дүгнэлт

-агаарын дундаж температур нь бүх нутгаар 0-2 градус орчмоор сэрүүн буюу ойролцоо

-өдрийн хамгийн их температур 2-6 орчим градусаар дулаан

-шөнийн хамгийн бага температур 3-8 градус орчмоор сэрүүн

-сум тус бүрээр тунадасны нийлбэр өмнөх оны 8-р сараас нутгийн зүүн хойд, төв, баруун өмнөд хэсгээр ахиу, Нөхөрлөлд 54,7, газар тариалангийн бүс нутгаар 6,6-91,6 мм-ээр, Цээлд 91,6 ээр бага бороо оров.

- салхины их хурд нийт нутгаар 4-14 м/с, борооны өмнө түр зуур 18-23 м/с, Эрдэнэсантад 23 м/с хүрч ширүүслээ.

- 2016 ОНЫ ЕСДҮГЭЭР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Төв аймгийн нутгаар: Агаарын температурын сарын дундаж нь нутгийн зүүн хойд хэсгээр 4-9 градус, бусад нутгаар 9-14 градус дулаан буюу ихэнх нутгаар уур амьсгалын дунджаас 0.5-1.0 градусаар дулаан, харин Заамар, Залуучууд, Жаргалант, Угтаалын хойд хэсэг, Борнуурын баруун хойд хэсэг, С Дулаарах үе: Нэг ба хоёрдугаар арав хоногийн эхээр уулархаг нутгаар шөнөдөө 0-5 градус, өдөртөө 15-20 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 7-12 градус, өдөртөө 22-27 градус дулаан байна

Хүйтрэх үе: Хоёр, гуравдугаар арав хоногийн сүүлийн хагаст хүйтэрч сарын сүүлчээр уулархаг нутгаар шөнөдөө 6-11 градус хүйтэн өдөртөө 3-8 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 1-6 градус хүйтэн, өдөртөө 6-11 градус дулаан байх төлөвтэй.

Сэрүүсэх үе: Нэгдүгээр арав хоногийн дунд үеэс сэрүүсч арав хоногийн сүүлчээр нь уулархаг нутгаар шөнөдөө 3-8 градус хүйтэн, өдөртөө 6-11 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 0-5 градус дулаан, хөрсөн дээр 1-6 градус хүрч цочир хүйтэрнэ, өдөртөө 14-19 градус дулаан байх төлөвтэй.

Бусад хугацаанд: Уулархаг нутгаар шөнөдөө 0-5 градус хүйтэн, өдөртөө 13-18 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 3-8 градус, өдөртөө 17-22 градус дулаан байх төлөвтэй.

Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь уур амьсгалын дунджийн орчим байх төлөвтэй байна. Дундаж нь Сүмбэр, Борнуур, Батсүмбэрт 30-43 мм, бусад нутгаар 17-30 мм орчим байдаг. Нэгдүгээр арав хоногийн эхээр нутгийн зүүн болон хойд хэсгээр /Мөнгөнморьт, Борнуур, Батсүмбэр, Жаргалант, Цээл, Баянчандмань сумдын нутгаар/ дунд үеэр нь ихэнх нутгаар бороо орно. Дуу цахилгаантай. Нэгдүгээр арав хоногийн сүүлч болон сарын дунд үеэр зарим газраар, гуравдугаар арав хоногийн эхээр ихэнх нутгаар, дунд үеэр нь нутгийн хойд хэсгээр, сарын эцсээр зарим газраар хур тунадас, уулархаг нутгаар нойтон цас орох төлөвтэй.

Салхи нэгдүгээр арав хоногийн дунд үе болон сүүлч, хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр зарим газраар 16-18 м/с хүртэл ширүүсч шороон шуурга шуурах төлөвтэй.

Аравдугаар сарын цаг агаарын урьдчилсан төлөв

Аравдугаар сард. Уур амьсгалын дунджаар агаарын температурын сарын дундаж Төв аймгийн зүүн хэсгээр 0-4 градус хүйтэн, бусад нутгаар 0-5 градус дулаан байдаг. Энэ сард ихэнх нутгаар уур амьсгалын дунджийн орчим байх төлөвтэй.

Уур амьсгалын дунджаар хур тунадас ихэнх нутгаар 6-11 мм ордог. Энэ сард Төв аймгийн зүүн өмнөд хэсгээр уур амьсгалын дунджаас ахиу бусад нутгаар дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй



I.5 Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2016 оны эхний 8 сард аймгийн хэмжээнд 586 гэмт

хэрэг бүртгэгдэж 472 хүн холбогдож төр, иргэдийн өмчид 2632.9 сая₮-ийн хохирол учирлаа.


Гарсан гэмт хэргийн 35.8 хувь нь хулгай, 29.4 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний хэрэг, 15.9 хувь нь бусад хэрэг, 14.0 хувь нь замын осол, 4.1 хувь нь танхай дээрэм, 0.9 хувь нь хүн амины хэрэг тус бүр эзлэв. Батсүмбэр, Заамар, Сэргэлэн, Аргалант, Борнуур, Баянжаргалан, Эрдэнэ, Жаргалант, Баяндэлгэр, Баянчандмань, сумдад 10000 хүнд 319-67 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (55)-аас харьцангуй их байна.

Гэмт хэргийн тоо 2015 оны мөн үеэс 53 хэргээр буурлаа.

Зуунмод суманд 30, эмэгтэй 688 эрэгтэй нийт 718 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2015 оны мөн үеэс 74 хүнээр буурлаа.

Зураг I.8

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар




Гарсан гэмт хэргийн 15.2 хувь нь бүлгээр 23.8 хувь нь согтуугаар үйлдэгджээ.

Гэмт хэргийн улмаас 260 хүн гэмтэж 56 хүн нас барлаа.


Зураг I.9

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар



Зураг I.10

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр



Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2016 оны эхний 8 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 656 гүйцэтгэх хуудсанд нийт 3.72 тэрбум ₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс 9 гүйцэтгэх хуудсанд ногдох 534.7 сая ₮-ийн материалд шүүхийн байцаан шийтгэх ажиллагаа хийгдэж, биелүүлбэл зохих 647 гүйцэтгэх хуудасны 3.20 тэрбум ₮-өөс 272 хуудасны 430.7 сая ₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудасны тоогоор 42.04 хувь, үнийн дүнгээр 13.49 хувь болж 2015 оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 2.35 нэгжээр буурч, үнийн дүнгийн биелэлт 10,16 нэгжээр тус тус буурлаа.

II. Эдийн засгийн үзүүлэлт



II.1 Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбаруудын дүнгээр 2016 оны эхний 8 сард кассын орлого 277.1 тэрбум ₮, кассын зарлага 279.3 тэрбум ₮ болж, гүйлгээнд 232.3

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбарын нийт зээлийн багц зээлдэгчийн тоо 125058, зээлийн багцын дүн 409.8 тэрбум ₮, зээл авсан зээлдэгчийн тоо 44327 олгосон зээлийн дүн 73.61 тэрбум ₮ боллоо. Иргэдийн хувийн хадгаламжинд 8 сарын 31-ний байдлаар хугацаатай хадгаламж 36.4 тэрбум ₮, хугацаагүй хадгаламж 11.9 тэрбум ₮ байна. Иргэдийн харилцах дансны үлдэгдэл 8 сарын 31-ны байдлаар 231907 иргэний 8.3 тэрбум ₮ боллоо. ХААН, Төрийн, Хас, Капитал банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү 1.3-1.39 хувь, хугацаатай доод хүү 0.50-0.60 хувь, хугацаагүй дээд хүү 0.08-0.61 хувь, хугацаагүй доод хүү 0.50-0.60 хувьтай байна.



II.2 Төсөв, мөнгө

Төсвийн орлого 2016 оны эхний 8 сард орон нутаг ба аймагт төвлөрүүлснээр орлого 7.2 тэрбум ₮, зарлага 42.7 тэрбум ₮ болж, аймаг, орон нутгийн төсвийн орлогоор тооцоход орлогын төлөвлөгөө 102.77 хувь биелэгдэж, үндсэн нэрийн татварын орлогуудаас; ХХОАТ, бусад орлого, өмчийн татвар, бууны албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, газрын төлбөр, ойгоос түлээ, мод ашигласны төлбөр, агнуурын нөөц ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, нохойн албан татвар, бусад төлбөр, хураамжийн төлөвлөгөө биелэгдсэнгүй. Аймгийн төсвийн орлого 2015 оны мөн үеэс 2.3 хувь буюу 161.9 сая ₮-өөр өслөө. Аймгийн төсвийн орлогын 88.65 хувийг татварын, 10.45 хувийг татварын бус, 0.90 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь 2015 оны мөн үеэс

татварын орлого 5.10 нэгжээр, татварын бус орлого 4.07 нэгжээр тус бүр өсч, хөрөнгө борлуулсны орлого 1.02 нэгжээр буурлаа.

Аймгийн нийт 3 шатны орлого 11.2 тэрбум ₮ болж аймгийнх 6.1 тэрбум ₮ буюу 54.89 хувь, сумынх 1.1 тэрбум ₮ буюу 9.95 хувь, улсынх 3.9 тэрбум ₮ буюу 35.17 хувийг тус бүр бүрдүүлжээ. 2015 оны мөн үеэс төсөвт байгууллагуудын өглөг 64.4 хувь буюу 571.9 сая ₮-өөр өсч 1.4 тэрбум ₮ болж, авлага 74.0 хувь буюу 102.5 сая ₮-өөр өсч 241.0 сая ₮ боллоо.

Орон нутгийн төсвийн орлого 7.3 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 101.25 хувиар биелэгдэж. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 1.1 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 101.33 хувь биелж, Баянхангай, Баянцагаан, Угтаал, Заамар, Батсүмбэр, Аргалант, Баянцогт, Баян, Борнуур, Сүмбэр, Архуст, Эрдэнэ, Дэлгэрхаан, Эрдэнэсант, Баян-Өнжүүл, Мөнгөнморьт, Сэргэлэн, Алтанбулаг сумд 57.1-3.5 хувиар тасалдууллаа.

Аймагт төвлөрүүлэх төсвийн орлогын төлөвлөгөө 6.1 тэрбум ₮ болж 103.03 хувь биелж Угтаал, Баянцагаан, Эрдэнэ, Баянцогт, Сүмбэр, Жаргалант, Баянхангай, Эрдэнэсант, Баян, Баянжаргалан, Борнуур, Зуунмод, Мөнгөнморьт, Дэлгэрхаан сумд төлөвлөгөө 36.3-0.3 хувиар тасалдууллаа.



II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

2016 оны 8 дугаар сард ХҮИ /хэрэглээний үнийн индекс/ суурь үе болох 2010 оны 12 дугаар сараас 64.98%, өмнөх оны мөн үеэс 3.20%-аар тус тус өсч, өмнөх сараас 0.51 хувиар буурав. ХҮИ-ийн 2016 оны 8 дугаар сарын 0.51 хувийн бууралтад хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 0.65 нэгжийн бууралт нөлөөлөв.

Хэрэглээний үнийн аймгийн индекс (өмнөх оны 12 сар=100)



ХҮИ өмнөх оны мөн үеэс 3.20% өссөний дотор хувцас бөс бараа гутлын бүлэг 7.63%; бусад бараа, үйлчилгээний бүлэг 7.30%; тээврийн бүлэг 5.07%; гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 4.51%; орон сууц, ус цахилгаан, хийн түлшний бүлэг 3.80%; зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлэг 1.87%; эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 1.52%; амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлэг 1.34%; согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлэг 0.54%-аар тус тус өсч, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлэг 4.18%; хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 1.93%-аар тус тус буурав. Боловсролын үйлчилгээний бүлэг үнэ тогтвортой байв.

Бараа, үйлчилгээний бүлэг	2016 оны 8 сард	
	пунктээр	хувиар
Бүгд	-0.51	100.00%
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	-0.65	125.45%
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	0.00	0.00%
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	0.04	-8.74%
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	0.00	-0.27%
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	-0.01	1.97%
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
07. ТЭЭВЭР	0.00	0.00%
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.01	-2.30%
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.08	-16.10%



II.5 Аж үйлдвэр


Өмчийн бүх төрлийн аж үйлдвэрийн газрууд 2016 оны эхний 8 сард (2005 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 25.85 тэрбум ₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2015 оны мөн үеэс 3.9 хувь буюу 0.97 сая ₮-өөр өслөө.

Зураг II.6 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, оны

үнээр, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР INDUSTRIAL SECTOR	2015 YII	2016 YII	2015 I-YII	2016 I-YII	Дүнд заах % Percentage share to total		2016% 2015%
					2015-I-YII	2016-I-YII	
Нийт дүн	2,247.08	3,679.10	24,870.75	25,849.47	100.0	96.7	103.9%
Ашигт малтмал олборлолт mining and quarrying	1,098.15	2,044.21	20,402.74	22,494.84	85.36%	87.02	110.3%
Боловсруулах аж үйлдвэр / manufacturing/	1,147.93	1,626.67	3,464.31	2,505.63	10.24	9.69	72.3%
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл Electricity, thermal energy, steam	1	8.22	1,003.69	849.01	4.4	3.28	84.6%

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн нь ашигт малтмал олборлолт, хувцас үйлдвэрлэл, модон эдлэл үйлдвэрлэл, ус хариутгал хангамж үйлдвэрлэл өмнөх оноос 4 дахинаас 7.8 хувь буюу 2.09 тэрбумаас-5.76 сая ₮-өөр өссөн нь нөлөөлөв.



Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Заамар, Жаргалант, Баянчандмань, Зуунмод, Баянцогт, Баянцагаан, Эрдэнэ, Батсүмбэр сумд 48.21-0.52 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 97.61) хувийг эзлэв.



II.6 Барилга


Төв аймгийн барилгын гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагууд 2016 оны эхний 8 сард 1755.5 сая ₮-ийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэлээ. Гүйцэтгэлийг 2015 оны мөн үетэй харьцуулахад 32.44 хувь буюу 843.0 сая ₮-өөр буурав.

Барилга угсралт, их засварын ажлын 70.44 хувь нь орон сууцны бус барилгад; 24.20 хувь нь инженерийн барилга байгууламжид; 5.35 хувь нь орон сууцны барилгад ногдож байна. Энэ нь 2015 оны мөн үетэй

харьцуулахад орон сууцны бус барилгын ажил 39.46 пунктээр өсч, орон сууцны барилгын ажил 4.19 пунктээр, инженерийн барилга байгууламжийн ажил 35.27 пунктээр тус тус буурав.

Зураг II.8

Барилга угсралт, их засварын ажил жил бүрийн 8 дугаар сарын байдлаар, сая.₮




II.7 Холбоо

Холбоо ашиглалтын орлого оны эхний 8 сард 120.4 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 52.6 сая ₮ болж, нийт орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.3 хувь буюу 21.8 сая ₮-өөр буурлаа.

Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 64.7 сая ₮ болсон ба нийт орлогын 79.1 хувь нь хүн амд үйлчилсний орлого байна. Нийт орлогын 20.84 хувийг албан бичгийн, 10.8 хувийг зорчигчдын, 68.36 хувийг бусад орлого бүрдүүлжээ.

Зураг II.10

Холбоо ашиглалтын орлого, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр



Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл.

Оюуны өмч, Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 8 сард нийт 907 иргэд, аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгөд бүртгэл хийснээс үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл 23; төрөөс үнэгүй өмчлүүлсэн газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл 333; газар эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл 4; бэлэглэлийн гэрээ 20; худалдах, худалдан авах гэрээ 57; өв залгамжлал 12; барьцааны гэрээний бүртгэл 196; бусад бүртгэл 262 тус бүр бүртгүүлээ.

Оюуны өмч, Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээгээр 2016 оны эхний 8 сард нийт 94 аж ахуйн нэгж шинээр бүртгүүлснээс хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ 56 ; нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага /НҮТББ/ 16; шашин 3; боловсрол сургалтын байгууллага /БСБ/ 1; гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага /ГҮТББ/ 6; үйлдвэрчний эвлэлийн байгууллага /ҮЭБ/ 4; Төсөвт 3; Хоршоо 3; бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл /ББН/ 1; орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /ОНӨААТҮГ/ 1 тус бүр бүртгүүлээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн 2016 оны 8 сарын мэдээгээр 144 аж ахуй нэгж байгууллага нэмэлт өөрчлөлт хийлгэснээс үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 36; гишүүн нэмэгдсэн, хасагдсан 21; дүрэм шинэчилсэн 4; дахин гэрчилгээ 8; удирдлага өөрчлөгдсөн 18; үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн 13; дүрмийн сан нэмэгдсэн, хасагдсан 20; хаяг өөрчлөгдсөн 2; нэр хэлбэр өөрчлөгдсөн 9;

татан буугдсан 13; тус бүр бүртгүүлээ. Мөн 40 иргэн, 12 хуулийн этгээдэд лавлагаа олголоо.

Стандартчилал хэмжилзүй

Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн 2016 оны эхний 8 сарын мэдээгээр нийт 243 аж ахуй нэгж иргэнд стандартын салбар сангийн үйлчилгээ үзүүлснээс тохирлын баталгаажуулалт 329; үүнээс тохирлын гэрчилгээ 274, дотоодын бүтээгдэхүүний баталгаажуулалт 55; хэмжих хэрэгслийн баталгаажуулалт 2549; үүнээс цулын хэмжүүр 532, жин 450, туухай 72, автомашины жин 10; эзэлхүүн зарцуулалтын хэмжүүр 274; үүнээс түгээгүүрийн хэмжүүр 185, мерник 9, шингэн бүтээгдэхүүнийг хэмжих хэрэгсэл 10, сүмбэн метр 25, уртын хэмжих хэрэгсэл 7, усны тоолуур 38; нэг фазын тоолуур 1721, гурван фазын тоолуур 22, даралтны аппарат 5 тус бүр баталгаажуулсан байна.